



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Баян-Агт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/11/СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.bulgan@audit.mn

Булган аймаг
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал.....	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.

Аудитын гэрчилгээ

	
БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	БАЯН-АГТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Ж.ГАНБОЛД ТАНАА
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580	
2020.03.24 № 129	
танай _____-ны № _____ т	

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Агт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Агт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Агт сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020204

Үүрэг, хариуцлага

Баян-Агт сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

Аудитын тайлан

2.1. Оршил

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн төвлөрүүлэн захирагч Ж.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 22-ноос 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/74 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь тухайн сум орон нутгийн нутаг дэвсгэр дээр төрийн хуулийг хэрэгжүүлэн, ард иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй хэвийн үзүүлэхэд оршино.

Сумын Засаг даргын захирамжаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- **Нийгмийн салбарын хүрээнд**
- Сургуулийн өмнөх ба сургуулийн боловсролын орчин, нөхцөлийг сайжруулах ажлуудыг зохион байгуулах, хөрөнгө оруулалт хийх
 - Орчин нөхцөлийг сайжруулах, аюулгүй тайван орчин бүрдүүлэх
 - Хүн амын хоол хүнс, ундны усны аюулгүй байдал, хүртээмжийг хангахад чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулах
- **Хөдөө аж ахуй, байгаль орчин, чиглэлээр**
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг биржийн сүлжээнд холбох, боловсруулах ажлыг дэмжих
- Эрчимжсэн аж ахуй, өрхийн орлого нэмэгдүүлэх санал санаачилгуудыг дэмжих
- Орон нутгийн хамгаалалтад авсан газруудад зорилтот ажлуудыг зохион байгуулах, хог хаягдлын асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарах
- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр худаг гаргах, булгийн эх хаших
- Үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалт, ургалтыг дэмжих, хадлан тэжээл бэлтгэлийг дэмжих
- **Дэд бүтцийн салбар**
- Зураг төсөв нь хийгдсэн, төсөв нь батлагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх /Хануйн ангархайн зам засвар, Эрүүл мэндийн төвийн их засвар, Инженерийн шугам сүлжээ, Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв/
- Зам даваа засварлах, үйлчилгээний техник хэрэгслийн байнгын ажиллагааг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжууд Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Төсөв баталсан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Төсөв баталсан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох)
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох)
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн 228 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)
- Сангийн сайдын 2007 оны 11 дугаар сарын 30 -ны өдрийн 326 дугаар тушаал (Журам батлах тухай Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар)
- Төрийн албаны шинэчлэгдсэн хуулийн дагуу байгууллагуудын дотоод журам
- Санхүүгийн тайлан гаргахтай холбоотой НББ-ийн бодлогын бичиг баримтыг байгууллага тус бүр дээр шинэчлэн нэмэлт оруулсан

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Агт сумын төсөвт байгууллагууд санхүүгийн алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Сангийн яамны ЗГУТСистем, СТС ХХК-ны НББ-ийн программ, нярвын программ хангамж ашигладаг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баян-Агт сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд нийт зардлыг сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3546708.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 70934.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 70934.1 мянган төгрөгөөр тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90124.1 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө -29852.5 мянган төгрөгийн бууралт, авлага, урьдчилж гарсан зардал -30492,5 мянган төгрөгийн бууралт, бараа материалын нөөц 13110.8 мянган төгрөгийн өсөлт, үндсэн хөрөнгийн 239770.9 мянган төгрөгөөр өссөн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	60095,6	30243,1	-29852,5
Авлага	299340,9	268848,4	-60492,5
Урьдчилгаа			
Бараа материал	380651,6	393762,4	13110,8
Үндсэн хөрөнгө	5298447,1	5333641,4	35194,3
Нийт хөрөнгө	6038535,2	6128659,3	90124,1
Өр төлбөр	4896,9	4144,9	-752,0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2281025,2	2085272,2	195753,0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6038535,2	6128659,3	90124,1

Авлага дансны үлдэгдэл буурсан нь Эмийн эргэлтийн сангийн өмнөх оны авлага, эргэн төлөгдөх зээлийн авлага буурсантай шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2016-2018 онуудад үүссэн, он удаан жил болсон мянган төгрөгийн байгууллагаас /хувь хүнээс/ авах 262814,3 мянган төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага 13 зээлдэгчийн 85826.5 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материал оны эцэст 393762.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь ашиглалтгүй бараа материалын үлдэгдлийг нэмэгдүүлэх талтай ч дараа оны төсвийг хэмнэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар 231025.9 мянган төгрөг, хандиваар 62297.7 мянган төгрөг бусад 51050.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй 399.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 18300.0 мянган төгрөг, акталсан 9991.3 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь Эмийн эргэлтийн сан цалингийн өглөгийг барагдуулсан шалтгаалжээ.

Бусад 43.0 мянган төгрөгийн өр нь ЭМТ-ийн хувь хүмүүст өгөх өглөг нь дансны нэр буруу бичсэнээс буцаж ирсэн нь өрийн үлдэгдлийг нэмэгдүүлэх шалтгаан болжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгад Цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангаар Засгийн газрын сан 95616502.48 төгрөгийг Сангийн яамны **Э-ТАЙЛАН-д** өмчийн өөрчлөлтийн тайланд 291369447.38 төгрөгөөр, аудитлагдсан тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд 354276452.78 төгрөгөөр илэрхийлэгдсэнийг Э-ТАЙЛАН-д 158523507.88 төгрөгөөр илэрхийлэгдсэн нь 195752944.82 төгрөгийн зөрүүг залруулж Засгийн газрын санг 195752944.82 төгрөгөөр хорогдуулж дахин үнэлгээний зөрүүг 195752944.82 төгрөгөөр нэмэгдүүлж залруулах бичилт хийсэн.

2019 оны нэгдсэн тайланд байгууллагын тайлангуудын нэгтгэлээр 2085272231.42 төгрөг болж НББ-ийн өөрчлөлтөөр -195752944.82 төгрөгийг хасч Дахин үнэлгээний нөөц дансанд залруулав. / цэцэрлэг 2018 он/

Өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнд эрүүл мэндийн төв 2018 онд бүртгэлд аваагүй бараа материал, хөрөнгийг бүртгэлд авч өмнөх үеийн үр дүнд хаасан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баян-Агт суманд тайлант 2019 онд 117910.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 119313.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	4500,0	6749,9	2249,9	150
Хөрөнгийн орлого	19500,0	24840,2	5340,2	129,4
Шууд бус орлого	40703,0	38303,2	-2399,8	94,1
Бууны албан татвар	5927,5	4158,0	-1769,5	70,15
Улсын тэмдэгтийн хураамж	4200,0	2463,5	-1736,5	58,65
ТТАМАТөлбөр	1200,0	1312,5	112,5	109,37
Хог хягдал үйлчилгээний хураамж	4500,0	4556,1	56,1	101,25
Ойн нөөц ашигласны төлбөр	19638,1	20251,9	613,8	103,13
Ан амьтан нөөц ашигласны төлбөр	942,0	770,0	-172,0	81,74

Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6000,0	6683,6	683,6	111,39
Хүү торгуулийн орлого	4800,0	3758,7	-1041,3	78,31
ТБӨОрлого	3500,0	3648,5	148,5	104,24
Нийт дүн	117910.6	119313.7	1403.1	101.19

Орон нутгийн орлого нийт дүнгээрээ орлого 1403.1 мянган төгрөгөөр давсан нь хадгаламжийн хүүгийн орлого, ойн нөөц ашигласны төлбөр, үйл ажиллагааны орлогууд давж биелснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 431689.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 426119.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 5570.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2324908.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 1470014.5 мянган төгрөг орон нутгийн төсвөөс, 643259.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 33100.0 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 3500.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 178535.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээнд 5570.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 5570.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2197992.1 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь урсгал зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 281279.9 мянган төгрөг, байгууллагаас 609961.7 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 609961.7 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 2179.4 мянга нийт 618172.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 614751.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3420.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 1254.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 1254.6 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 2249.8, хөрөнгийн орлого 5340,1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц

ашигласны төлбөрийн орлого 112.4, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 56.0, ойн нөөц ашигласны төлбөр 613.7, ус рашааны нөөц ашигласны төлбөр 683.6, мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол шууд бус орлого 2399.8, ан амьтны нөөц ашигласны төлбөр 172.0, хүүгийн орлого 1041.2, бусад орлого 682.2, тухай жилийн үйл ажиллагаанаас үл хамаарах бууны албан татвар 1769.5, улсын тэмдэгтийн хураамж 1736.5 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 5086.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 2422.1 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 2128.1 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 536.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баян-Агт сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баян-Агт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 1254.6 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 2249.8, хөрөнгийн орлого 5340.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 112.4, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 56.0, ойн нөөц ашигласны төлбөр 613.7, ус рашааны нөөц ашигласны төлбөр 683.6, мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол шууд бус орлого 2399.8, ан амьтны нөөц ашигласны төлбөр 172.0, хүүгийн орлого 1041.2, бусад орлого 682.2, тухай жилийн үйл ажиллагаанаас үл хамаарах бууны албан татвар 1769.5, улсын тэмдэгтийн хураамж 1736.5 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 5086.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 2422.1 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 2128.1 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 536.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

3.3 Удирдлагатай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь тус хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн байна.

3.3.1 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх.

3.3.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын хавсралтаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам" мөрдөн ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

Төсвийн төврүүлэн захирагч зөвшөөрсөн дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	740.088.156,10	692.853.905,39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	60.095.624,08	30.243.081,51
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	11.753,00	11.753,00
31140	Касс арилжааны банк	11.753,00	11.753,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	60.083.871,08	30.231.328,51
3121	Төгрөг	60.083.871,08	30.231.328,51
31211	Төрийн сангийн харилцах	60.059.800,64	29.729.676,30
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	24.070,44	501.652,21
33	АВЛАГА	299.340.949,32	268.848.436,83
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	66.379,00	1.935.379,49
33401	Дансны авлага /ТӨҮГ/	373.397,50	567.616,00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	30.090,00	
335	Бусад авлага	298.871.082,82	266.345.441,34
3351	Байгууллагаас авах авлага	39.450.733,57	3.531.110,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	259.420.349,25	262.814.331,34
35	БАРАА МАТЕРИАЛ	380.651.582,70	393.762.387,05
351	Түүхий эд материал	29.720.245,91	96.005.272,52
35110	Тусгай зориулалттай материал	26.276.872,91	91.288.539,37
35130	Эм боох материал	3.443.373,00	4.716.733,15
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2.212.124,00	
354	Хангамжийн материал	311.434.212,79	259.117.114,53
35410	Бичиг хэргийн материал	7.271.390,00	5.313.082,00
35420	Аж ахуйн материал	199.283.866,07	201.993.002,71
35430	Сэлбэг хэрэгсэл	6.150.885,00	1.372.000,00
35440	Түлш, шатах тослох материал	37.962.193,20	355.548,00
35450	Барилгын засварын материал	402.000,00	
35460	Хүнсний материал	3.893.564,49	5.143.524,29
35470	Бусад хангамжийн материал	56.470.314,03	44.939.957,53
35600	Мал амьтад	37.285.000,00	38.640.000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5.298.447.086,46	5.435.805.361,90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5.298.447.086,46	5.435.805.361,90
392	Биет хөрөнгө	5.196.899.086,50	5.333.641.361,96
39201	Барилга, байгууламж, орон сууц	4.228.148.591,03	4.474.174.537,03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(220.056.521,92)	(347.328.276,73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	349.529.800,00	343.589.800,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(234.846.533,49)	(263.915.250,21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	557.164.813,47	635.449.172,47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(411.744.970,08)	(462.314.286,33)

Баян-Агт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	207.423.600,81	239.706.159,83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(122.339.983,36)	(132.545.713,57)
39209	Зам, гүүрийн байгууламж	793.623.014,40	793.623.014,40
39210	Хуримтлагдсан элэгдэл		(11.881.640,16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42.461.454,50	55.461.454,50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26.468.741,93)	(30.428.932,34)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	34.004.563,07	40.051.323,07
393	Биет бус хөрөнгө	101.547.999,96	102.163.999,94
39301	Програм хангамж	3.590.000,00	4.340.000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2.720.000,04)	(2.854.000,06)
39303	Бусад биет бус хөрөнгө	100.678.000,00	100.678.000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6.038.535.242,56</u>	<u>6.128.659.267,29</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4.896.959,10</u>	<u>4.144.966,86</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4.896.959,10	4.144.966,86
413	Өглөг	4.896.959,10	4.144.966,86
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	795.055,00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	63,26
4136	Бусад өглөг	4.101.904,10	4.144.903,60
41361	Байгууллагад төлөх өглөг	4.101.904,10	4.101.904,10
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	42.999,50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6.033.638.283,46</u>	<u>6.124.514.300,43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6.033.638.283,46	6.124.514.300,43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2.281.025.176,24	2.281.025.176,24
512	Хуримтлагдсан үр дүн	2.179.434.465,60	2.270.310.482,57
51210	Өмнөх үеийн үр дүн	696.653.796,79	2.180.959.165,60
51220	Тайлант үеийн үр дүн	1.482.780.668,81	89.351.316,97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1.573.178.641,62	1.573.178.641,62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6.038.535.242,56</u>	<u>6.128.659.267,29</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4.317.378.105,89	3.634.489.762,59
11	ТАТВАРЫН ОРЛОГО	100.270.095,15	110.088.709,66
110	Орлогын албан татвар	56.743.322,15	69.893.241,77
1100	Хувь хүний орлогын албан татвар	56.743.322,15	69.893.241,77
110002	Үйл ажиллагааны орлого	4.943.800,00	6.749.870,90
110003	Хөрөнгийн орлого	19.108.776,15	24.840.181,52
110008	Шууд бус орлого	32.690.746,00	38.303.189,35
113	Хөрөнгийн албан татвар	5.662.000,00	4.158.000,00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		
113002	Бууны албан татвар	5.662.000,00	4.158.000,00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37.864.773,00	36.037.467,89
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7.735.338,00	8.332.013,89
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3.085.338,00	2.463.450,00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	200.000,00	1.312.470,00

Баян-Агт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.450.000,00	4.556.093,89
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	30.129.435,00	27.705.454,00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	25.046.585,00	20.251.854,00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	580.000,00	770.000,00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4.502.850,00	6.683.600,00
